



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/27

Мандалговь

Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 /а/, 29.2, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 17 дугаар зүйлийн 17.1, 17<sup>1</sup>.1, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.8, 7.2.16, 34 дүгээр зүйлийн 34.18 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын 2020 оны үзлэг, шинэчилсэн бүртгэл, татвар хураамж хураах ажлыг зохион байгуулах аймгийн комиссыг нэгдүгээр, сумдад ажиллах комиссыг хоёрдугаар, үзлэгийн хуваарийг гуравдугаар хавсралтаар баталсугай. Хоёр. Аймгийн хэмжээнд бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулах үйл ажиллагааг жилийн турш жигд, чанартай зохион байгуулж, холбогдох стандартуудын шаардлагыг хангуулах, гаалийн бүрдүүлэлттэй мотоциклыг бүртгэлжүүлэх, ашиглах боломжгүй тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулах ажлыг зохион байгуулахыг Автотээврийн төвийн дарга (Ц.Бямбацогт)-д үүрэг болгосугай.

Гурав. Тус аймгийн иргэд байгууллагын эзэмшилд бүртгэлтэй байгаа автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон нутгийн авто зам ашигласны төлбөр хураамжийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу 6 сарын 1-ний дотор хураан төсөвт төвлөрүүлэхийг Татварын хэлтсийн дарга (М.Туяацэцэг)-т үүрэг болгосугай.

Дөрөв. Техникийн хяналтын үзлэгт сумынхаа албан байгууллага, иргэдийн болон нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудын тээврийн хэрэгслийг бүрэн хамруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Тав. Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлд хамрагдсан байдал, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, орон нутгийн авто зам ашигласны төлбөр төлөлт, жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсан байдалд бүтэн жилийн турш хяналт шалгалтыг тасралтгүй хийж, зөрчлийг тухай бүр арилгуулахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, хурандаа (О.Амарсанаа), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат), автотээврийн болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч, зохицуулагч нарт үүрэг болгосугай.

Зургаа. Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, татвар хураалтын үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулж ажилласан дүн мэдээг үндэслэн аймгийн Засаг даргатай сумдын Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээнд тусган биелэлтэд дүгнэлт өгч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир)-д даалгасугай.

482010027

Долоо. Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, татвар төлөлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлын үр дүнг улирал тутамд танилцуулж ажиллахыг Автотээврийн төвийн дарга (Ц.Бямбацогт), Татварын хэлтсийн дарга (М.Туяацэцэг), захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир) нарт тус, тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2020 оны  
02 дугаар сарын 17 ний өдрийн 17 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ШИНЭЧИЛСЭН  
БҮРТГЭЛ ЯВУУЛАХ АЙМГИЙН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН


Комиссын дарга: Ц.Бямбацогт (Автотээврийн төвийн дарга)  
Гишүүд: О.Амарсанаа (Цагдаагийн газрын дарга хурандаа)  
М.Туяацэцэг (Татварын хэлтсийн дарга)  
Н.Батболд (Мэргэжлийн хяналтын газрын Тээвэр авто,  
өргөх механизмын хяналтын улсын байцаагч)  
Б.Бадамханд (Албан журмын даатгагчдын холбооны  
Дундговь аймаг дахь салбарын менежер)

Аймгийн Засаг даргын 2020 оны  
02 дугаар сарын 07-ний өдрийн 9/07 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ШИНЭЧИЛСЭН БҮРТГЭЛ, ТЕХНИКИЙН  
ҮЗЛЭГ ЯВУУЛАХ СУМДЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Комиссын ахлагч: Э.Болормаа (Автотээврийн төвийн техникийн хяналтын  
үзлэгийн инженер)
- Гишүүд: Н.Сугармаа (Автотээврийн төвийн бүртгэлийн  
мэргэжилтэн)  
Д.Мөнхбадрах (Автотээврийн төвийн техникийн хяналтын  
үзлэгийн техникч)  
Сумдын цагдаагийн хэсгийн төлөөлөгч  
Сумдын татварын байцаагч

Аймгийн Засаг даргын 2020 оны  
 002 дугаар сарын 07-ний өдрийн 027 дугаар  
 захирамжийн гуравдугаар хавсралт



**ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ ХУВААРЬ**

№	Сум, багийн нэр	Хоног	Хугацаа
<b>Нэг. Төвийн бүс</b>			
1	АННэг, байгууллагууд	5	02 дугаар сарын 10-аас 02 дугаар сарын 15
2	Төсөвт болон ТББ-ууд	5	02 дугаар сарын 16-аас 02 дугаар сарын 20
3	Нийтийн такси үйлчилгээ	11	03 дугаар сарын 01-ээс 03 дугаар сарын 11
4	Сайнцагаан сумын 1-9-р багууд	18	03 дугаар сарын 12-оос 03 дугаар сарын 29 05 дугаар сарын 06-аас 05 дугаар сарын 31
<b>Хоёр. Зүүн бүс</b>			
1	Дэлгэрцогт	2	03 дугаар сарын 30-аас 03 дугаар сарын 31
2	Дэрэн	2	04 дүгээр сарын 01-ээс 04 дүгээр сарын 02
3	Цагаандэлгэр	1	04 дүгээр сарын 03
4	Говь-Угтаал, төмрийн уурхайнууд	2	04 дүгээр сарын 04-өөс 04 дүгээр сарын 05
5	Баянжаргалан, уурхайнууд	2	04 дүгээр сарын 06-аас 04 дүгээр сарын 07
6	Өндөршил	2	04 дүгээр сарын 08-аас 04 дүгээр сарын 09
7	Гурвансайхан Мөнгө, Лог, Хөөт гм уурхайнууд	2	04 дүгээр сарын 10-аас 04 дүгээр сарын 11
8	Өлзийт	2	04 дүгээр сарын 12-оос 04 дүгээр сарын 13
<b>Гурав. Баруун бүс</b>			
1	Луус	2	04 дүгээр сарын 16-аас 04 дүгээр сарын 17
2	Хулд	3	04 дүгээр сарын 18-аас 04 дүгээр сарын 20
3	Дэлгэрхангай	2	04 дүгээр сарын 21-ээс 04 дүгээр сарын 22
4	Сайхан-Овоо	2	04 дүгээр сарын 23-аас 04 дүгээр сарын 24
5	Эрдэнэдалай	4	04 дүгээр сарын 25-аас 04 дүгээр сарын 28
6	Адаацаг	2	04 дүгээр сарын 29-өөс 04 дүгээр сарын 30